

БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ж.ГАНТУЛГА

2018 оны ... дугаар сарын ... -ны өдөр

“ЦЭЭЖ БИЧИГ” НЭГДСЭН АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

2019.02.27

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 3-12 дугаар ангийн сурагчдын дунд эх хэлээрээ зөв сайхан, хичээнгүй бичих чадварыг сайжруулах, Монголын нэрт зохиолчдын уран бүтээлийг олны хүртээл болгох зорилгоор “Цээж бичиг” нэгдсэн ажиллагааг 2 дахь жилдээ зохион байгуулж байна. Нийслэлийн Боловсролын газраас “Цээж бичиг”-ийн эхийг анги тус бүрээр боловсруулан хүргүүлнэ.

2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр “Цээж бичиг” нэгдсэн ажиллагааг дараах зохион байгуулалтаар явуулна.

НЭГ. СУРГУУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 3-12 дугаар ангийн сурагчдыг бүрэн хамруулна.
2. Сэдвийг 10.00-10.30 цагийн хооронд НБГ-ын www.edub.edu.mn сайтад байршуулах ба сургалтын менежерүүд кодыг хийж сэдвийг татан авна. Сэдвийг зөвхөн бүлгийн тоогоор хэвлэж олшруулна.
3. Сургалтын менежерүүд татах кодыг холбогдох мэргэжилтнээс авна. (холбогдох утасны дугаар Л.Уртнасан 99164460, Р.Өлзийхүү 95131520)
4. Нэгдүгээр ээлжинд хичээллэж буй сурагчдаас 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 11.00, хоёрдугаар ээлжинд хичээллэж буй сурагчдаас 14.00, гуравдугаар ээлжинд хичээллэж буй сурагчдаас 16.00 цагуудаас тус тус цээж бичгийг авна.
5. “Цээж бичиг”-ийг монгол хэлний тууш дэвтрийн цаасан дээр цэвэр нямбай, алдаагүй, зөв сайхан бичүүлнэ.
6. “Цээж бичиг”-ийг тухайн ангид хичээл зааж буй багш авах ба сурагчдад хүндэтгэлтэй хандаж, сэтгэл зүйн, зөв орчин бүрдүүлж ажиллана. Шалгалтын үеэр багш, сурагчид гар утас ашиглахгүй.
7. Бага ангид “Цээж бичиг”-ийн эхийг эхлээд 1 удаа зөв тод уншиж өгсний дараа 2-3 үгээр хэлж өгөх ба үеэр тасалж болон үг үгээр хэлэхгүй.
8. Ижил дүрмийн алдааг нэг алдаанд тооцно. /Жишээ нь том үсгийн 4 алдаа байвал нэг алдаа гэж тооцно./
9. Ахлах ангийн сурагчдын хувьд алдаагүй бичсэн сурагчдад бүтээлч даалгаврын оноо өгч болно.
10. “Цээж бичиг”-ийн материалыг сургууль дээрээ бага ангийн болон монгол хэл, уран зохиолын мэргэжлийн багш нарын түвшинд тойргоор засаж дүнг анализын дагуу нэгтгэн дүүргийн Боловсролын хэлтэст ирүүлнэ.

ХОЁР. ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН ХЭЛТЭС

11. Дүүргийн Боловсролын хэлтэс дүнг нэгтгэн 2019 оны 2-р сарын 28-ны өдөр Нийслэлийн Боловсролын газарт емайлээр ирүүлнэ. (Бага анги urtnasan@edub.edu.mn, дунд ахлах анги ulziikhuu@edub.edu.mn)
12. Цээж бичгийн анализ, дүн мэдээг доорх өгсөн хүснэгтийн дагуу бөглөөд харьяа дүүргийнхээ хариуцсан мэргэжилтэнд тухайн өдрийнхөө 18.00 цаг гэхэд илгээсэн байна.

Цээж бичгийн үнэлгээний хүснэгт

№	Дүүрэг	Сургууль	Анги	Бүлэг	Нийт хамрагдсан сурагчдын тоо	Нийт авсан оноо	90-100%	80-89%	70-79%	60-69%	50-59%	40-49%	30-39%	0-29%
Нийт тоо														

ГУРАВ. УРАМШУУЛАЛ

Сургуулийн захиргаа цээж бичгийн үнэлгээг анги бүлэг бүрээр гаргаж, амжилт гаргасан анги бүлгийг байр эзлүүлэн урамшуулна. Мөн цээж бичгийн үнэлгээг монгол хэлний сургалтыг сайжруулахад судалгаа болгон ашиглана.

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР